

- Л.Дашнямын 1993-2012 оны хоорондох өдөр тутмын сонинуудад хэвлэгдсэн мэдээ, нийтлэлийн жагсаалтын он дарааллын ном зүй
- “Үндэсний бичиг үсгийн баяр–2025” арга хэмжээний хүрээнд “Монголчуудын үсэг бичгийн гарал үүсэл, сурах бичиг” сэдэвт мэдээлэл, ном зүйн жагсаалт,
- Санамж өгөх ном зүй: 1. Авлигын холбогдолтой мэдээ, мэдээлэл
- Улаанбаатар хотын тухай мэдье гэвэл” сэдэвт номзүйн мэдээллийг цахимаар 1 удаа, 73 номоор хийсэн болно
- Хорт зуршилтай холбоотой 54 ш номоор цахим номзүй
- Төр нийгмийн зүтгэлтэн, Төрийн шагналт, академич Б.Ринчений мэндэлсний 120 жилийг ойг тохиолдуулан уран бүтээлийн 39 ш номоор цахим номзүй
- Инээдмийн баярын өдрийг тохиолдуулан сан хөмрөгт байгаа 190ш хошин шог зохиолуудаар цахим номзүй
- Авилга хээл хахуулын талаар юу унших вэ? сэдэвт цахим номзүй
- Монголын уламжлалт анагаах ухаан /санамж өгөх номзүй/ 1 удаа цаасаар бэлтгэн 93 нэрийн номоор
- “Хотын соёлыг төлөвшүүлэх” сэдэвт цахим мэдээлэл, ном зүйн холбогдол бүхий богино хэмжээний видео контентуудыг бэлтгэн нийтэлж, уншигч, хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг ханган ажилласан байна.



- Ном хэвлэх, сэлбэн засах үйлчилгээ:

Улаанбаатар хотын нийтийн төв болон салбар номын сангуудын хэмжээнд урагдаж, гэмтсэн нийт 403 ширхэг номыг сэлбэн засварлаж, уншлага, үйлчилгээнд хүлээлгэн өглөө. Үүнд:

- Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сан – 180 ширхэг
- Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан – 25 ширхэг
- Хүүхдийн уншлагын танхим – 20 ширхэг
- Уншлагын А, Б танхим – 147 ширхэг
- Үндсэн фонд – 31 ширхэг

Мөн төв болон салбар номын сангуудын хэмжээнд 172 нэгж тогтмол хэвлэлийг нэгжлэн үдэж, хавтаслан байна. Үүнд:

- Төв номын сан – 33 нэгж
- Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сан – 25 нэгж
- Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан – 36 нэгж
- Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан – 36 нэгж
- Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сан – 42 нэгж



Түүнчлэн 55 нэгж баримт бичгийг үдэж, хавтаслан эмхэтгэн хадгалалтад шилжүүлсэн байна.



- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн үйлчилгээ

Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан уншлагын танхимаар дамжуулан тусгайлсан үйлчилгээ, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажилладаг.

Тайлант хугацаанд харааны бэрхшээлтэй 1,100 иргэнд танхимаар 235 ном, зөөврийн хэлбэрээр 652 ном, гэрээр 633 ном, нийт 1,520 ширхэг ном олгон үйлчилж, тэдний тэгш хүртээмжтэй мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллав.

Мөн харааны бэрхшээлтэй 150 иргэнд 150 удаагийн лавлагаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнээс утсаар 74, амаар 70, и-мэйлээр 6 удаа лавлагаа өгсөн байна.

Хөдөө, орон нутагт суралцаж буй харааны бэрхшээлтэй сурагчид болон тэдний асран хамгаалагчдад зориулан брайл бичгийн сургалтыг нийт 6 удаа зохион байгуулсан. Үүнээс 4 удаа онлайнаар, 2 удаа танхимаар явуулсан бөгөөд Увс, Хөвсгөл аймагт суралцаж буй сурагчид хүрэлцэн ирж сургалтад хамрагдсан байна. Мөн Дэлхийн номын баяр, Үндэсний бичиг үсгийн баярын өдөр-ийг тохиолдуулан ЕБС-ийн 116-р сургуулийн сурагчдын дунд Хүүхдийн зохиолч, МУСТА, МЗЭ-ийн гишүүн Ж.Батноовтой "Миний бага нас" сэдэвт уран бүтээлийн

уулзалт, өдөрлөгийг амжилттай зохион байгуулж, хүүхэд, залуучуудын ном унших сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүллээ.



Харааны бэрхшээлтэй уншигч, үйлчлүүлэгчдэд зориулсан "Туслах технологи, тусгай хэрэгсэл эзэмших" сургалтыг тайлант хугацаанд нийт 35 удаа зохион байгуулж, 79 иргэнийг хамруулан хэрэгжүүллээ.

Уг сургалтууд нь хүртээмжтэй 3 төрлийн технологийн чиглэлээр явагдсан бөгөөд "INFINITY SPACE" харааны бэрхшээлтэй хүүхэд, залуусын төсөл болон харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг дэмжих "Хөгжлийн туслалцаа" ТББ-тай хамтран дараах байдлаар зохион байгуулагдсан. Үүнд:

- 12–18 насны 20 харааны бэрхшээлтэй хүүхэд, залуусыг хамруулсан туслах технологийн 10 удаагийн сургалт,
- Харааны бэрхшээлтэй 15-н эмэгтэйчүүдийг хамруулсан технологийн 20 удаагийн сургалт,
- Тусгай хэрэгсэл эзэмших "цагаан таяг"-ийн 3 удаагийн сургалт, 1 оролцогч хамрагдсан.

Эдгээр сургалтаар харааны бэрхшээлтэй иргэдийн технологи ашиглах чадвар, бие даан хөдөлгөөн, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан байна.



"NVDA" дэлгэц уншигч программын 2025 оны шинэчлэлийн хуваарийн дагуу монгол хэлний орчуулгад 350 мөрөнд засвар хийж, 60 мөрийг шинээр орчуулснаар нийт 410 мөрийг сайжруулан шинэчилсэн байна.



"Jishuo" андройд дэлгэц уншигч аппликейшний монгол хэлний орчуулгыг шинэчлэлийн хуваарийн дагуу сайжруулж, 120 мөрөнд засвар хийж, 23 мөрийг шинээр орчуулснаар нийт 143 мөрийг шинэчилсэн байна.



- Олон нийтийг соён гэгээрүүлэх төрөл бүрийн ажил, үйлчилгээг зохин байгуулж ажиллах:

Тайлант онд Улаанбаатар хотын нийтийн төв болон салбар номын сангууд иргэдэд зориулсан нийт 953 соёл, танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулж ажиллаа. Үүнд:

Уулзалт, зочны ярилцлага

- Australian Smart School of Ulaanbaatar сургуулийн 2 дугаар ангийн дөрвөн бүлгийн 82 сурагчид номын сантай танилцаж, карт нээлгэн тус сургуулийн багш удирдлагуудын хүсэлтээр Д.Нацагдоржийн шагналт зохиолч Н.Мандалтай хамтран "Сайхан сэтгэлийн эрэлд" сэдвийн талаар
- Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төсвийн үйлчлүүлэгч, албан хаагчдад "Хөтөч гэрэл-Боловсрол хөгжлийн төв"-ийн захирал, сэтгэл судлаач, гэр бүл донтолтын зөвлөгч Л.Жаргалмаатай
- Америкийн худалдааны танхим бодлого хариуцсан захирал залуу зохиолч И.Гэрэлчулуунтай 6-р сургуулийн Б.Хоовон багштай 11г, Д.Сугармаа багштай 11б, Б.Нарандэлгэр багштай 12а ангийн нийт 88 сурагчид "Улаанбасган" номын тухай, Америкийн соёлын зөрүүний талаарх сэдвээр
- МУ-ын Хүний Эрхийн Үндэсний Комиссын сургалт хариуцсан референ О.Тодбулагтай 31-р сургуулийн н.Анхтуяа багштай 10а, З.Бүжидмаа багштай 10б, Б.Отгонцэцэг багштай 10в ангийн 96 сурагч нартай "Хүний эрх гэж юу вэ?" сэдвээр
- Олон Улсын оюун дасгалжуулагч, сургагч багш Ч.Отгонбаяр багштай хамтран "Амьдралд ойрхон харилцаа" сэдвээр
- Төрийн бус байгууллагын тэргүүн, Хүүхдийн зохиолч Анбатын Дэлгэржаргалтай 102 дугаар сургуулийн Г.Энхсүлд, З.Булган багштай 3в, 3г анги, Эрдэм-Алтай сургуулийн М.Оюунгэрэл багштай 1а анги, 28дугаар сургуулийн Ц.Одгэрэл багштай 4б ангийн сурагчид хамрагдаж өөрсдийн уншсан Динза, Цондоолой Цүндээлэйгийн тухай
- Хүүхдийн зохиолч Б.Энхжаргал хүүхэддэйн баатруудын хамт 35 дугаар цэцэрлэгийн Мажигсүрэн, Пүрэвсүрэн багштай бэлтгэл "В" бүлэг, Д.Болортогос, У.Номуундарь багштай бэлтгэл "З" бүлэг, С.Өлзиймаа, Ц.Шархүүхэн багштай бэлтгэл "Е" бүлгийн хүүхдүүд хамрагдсан.

- "ДИНЗА, ЦОНДООЛОЙГИЙН АНД НАЙЗУУД төрийн бус байгууллагын тэргүүн, Хүүхдийн зохиолч Анбатын Дэлгэржаргалтай "ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН" уулзалт
- Үсгийн эрэлд" цуврал номын зохиолч М.Алтаннартай уулзалт хийсэн. Мөрөөдөлдөө хүрэх тасалбараа авахын тулд үсгээ хэрхэн цуглуулах талаар үйл явдалтай уулзалт.
- Дэлхийн номын өдрийг тохиолдуулан "ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН" уулзалтыг Хүүхдийн зохиолч Б.Энхжаргал хүүхэддэйн баатруудын хамт зохион байгуулсан.
- Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны НЕБ-ийн 152 дугаар сургуулийн номын санд "Зохиолч-уншигчдын уулзалт" зохион байгуулж, МЗЭ-ийн шагналт зохиолч, сэтгүүлч Х.Энхбат 58 сурагчтай уулзан шинээр хэвлүүлсэн "Хайс овогт жанжин Д.Сүхбаатар" номоо танилцууллаа.
- МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Ч.Наранцэцэгтэй зохиолч-уншигчдын уулзалтыг 127 дугаар сургуулийн 7б, 7г ангийн 63 сурагчийн оролцоотой зохион байгуулж, "Ном уншихын ач тус" болон чөлөөт сэдвээр
- МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Н.Мандалтай зохиолч-уншигчдын уулзалтыг 127 дугаар сургуулийн 5в ангийн 40 сурагчийн оролцоотой зохион байгуулж, зохиолчийн уран бүтээлийн замнал болон чөлөөт сэдвээр
- МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Г.Ганболдтой хамтран "Миний мэдэх дуу" нэртэй уулзалт
- МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч П.Наранбаатартай хамтран "Би унших дуртай" сэдэвт уулзалт
- БЗД-ийн 1-р хорооны амадуудтай "Номын сантай танилцах уулзалт" сэдэвт уулзалт "Сэтгэл зүйн эрүүл мэнд ба эерэг сэтгэлгээ" сэдэвт уулзалтыг БЗД-ийн 3 дугаар хорооны иргэдэд хийсэн
- БЗДүүрэг дэх иргэдийн хурлын төлөөлөгч Бүрэнтөгстэй хамтран "Номын санд ном уншихыг дадал болгоё" уулзалт
- МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Б.Ганбаатартай зочны ярилцлага



- Милко трейд ХХК-ийн Импортын боруулалтын албаны дарга, зохиолч Энхбаатарын Ундрахтай зочны ярилцлага
- МҮОНР-ийн уран зохиол, урлаг соёлын албаны редактор, сэтгүүлч, зохиолч Баттөрийн Даариймаатай зочны ярилцлага
- ЗЭ-ийн болон "Алтан өд", МСНЭ Ц.Балдоржийн нэрэмжит шагналт, бэлтгэлд байгаа дэд хурандаа, зохиолч, сэтгүүлч Г.Баатарнумтай зочны ярилцлага
- Яруу найрагч Б.Болормаа
- Зохиолч Б.Урангоо
- Сэтгүүлч, яруу найрагч Э.Гантөмөр
- "Аримун" продакшны үүсгэн байгуулагч, жүжигчин Д.Ганцэцэг
- "Хөлгөн туульс", "Язгуур аялгуу" хамтлагийг үүсгэн байгуулагч "Дэлхийн эсгий туургатны язгуур өв соёл, ёс заншлын төв" байгууллагын тэргүүн Э.Баатаржав
- Эрүүл зөв хооллолтын үйлдвэр, SeeZam компанийн үүсгэн байгуулагч З.Маргарита
- Little Mom подкастын үүсгэн байгуулагч Б.Баянзул
- Д.Нацагдоржийн шагналт зохиолч А.Лхагва
- Чөлөөт уран бүтээлч, шог зураач С.Цогтбаяр
Монголын үндэсний олон нийтийн телевизийн өглөө хөтөлбөрийн сэтгүүлч
Зохиолчдын эвлэлийн гишүүн, Сэр-Одын нэмэржит шагналт зохиолч Б.Дэлгэрцэцэг
- Америкийн худалдааны танхим бодлого хариуцсан захирал залуу зохиолч И.Гэрэлчулуун
- Зохиолч Ж.Амгаланбаатар
- Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн статистик хариуцсан референт Э.Ганцэцэг
- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Сурвалж бичиг, төвд судлалын салбарын ЭШТА, доктор / Ph.D/ профессор Д.Наранцэцэг
- Хэл бичгийн ухааны доктор (Ph.D), профессор Р.Чүлтэмсүрэн
- Утга зохиол судлаач, шүүмжлэгч, хэл шинжлэлийн ухааны доктор Г.Батсуурь
- Залуу яруу найрагч Б.Дагвадулам
- Зохиолч С.Түмэнтэй ярилцлага



- Гэрэл зурагт номын мухлагийн үүсгэн байгуулагч, зурагт номын зураач, зохиолч Э.Мишээл
- Хүүхдийн ертөнцийг тэдний хэлээр, тэдний өнцгөөс харж, уран сэтгэмжээр дүүрэн зурагт номууд бүтээдэг "Болжмор Эду" компанийн үүсгэн байгуулагч, зохиолч Б.Энхжаргалтай зочны ярилцлага

гэх мэт уулзалт, зочны ярилцлагыг хийж, цахим сүлжээнд байршуулан олон нийтэд хүргэсэн байна.

Шидэт шоо хөтөлбөр:

Хүүхдийн уншлагын танхимаас зохион явуулдаг шидэт шоо хөтөлбөр нийт 14 удаа явагдаж 130 хүүхдийг хамруулсан байна.



Чанга уншлага, уншлагын цаг, бүтээлч уншлага хөтөлбөр:

Хүүхдийн уншлагын танхимаас зохион явуулдаг Чанга уншлага, уншлагын цаг, бүтээлч уншлага хөтөлбөр нийт 9 удаа явагдаж 216 сурагч, хүүхдийг хамруулсан байна.



Нийслэлийн Ерөнхий боловсролын Баянгол дүүргийн 93 дүгээр бүрэн дунд сургуулийн Сэвжид багштай, 47 дугаар сургуулийн Б.Мөнхжаргал багштай 7в анги, Сант сургуулийн Нарантуяа багштай 6б ангийн сурагчдыг тус тус хөтөлбөрт хамруулж, танхимаар үйлчилж, уншсан номын тэмдэглэл хөтлүүлэн, номын хэлэлцүүлэг зохион байгууллаа.



"Номын жим" аяллын хөтөлбөр

"Хотын соёл"-ыг төлөвшүүлэн түгээн дэлгэрүүлэх, номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд номын сангийн үйл ажиллагаатай танилцах "Номын жим" аяллын хөтөлбөрийг нийт 145 удаа зохион байгуулж, 4193 уншигч үйлчлүүлэгч, сурагчид тус тус хамрагдсан байна.



Номын жим аяллын хүрээнд уншигчдад номын сангийн уншлага, үйлчилгээ, цахим үйлчилгээ, хүүхдийн номын фонд, соёл боловсролын хөтөлбөр, бүтээлч үйл ажиллагаа болон сэтгэл зүй, хөгжлийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагааг танилцууллаа.



Бүтээлч уншлага:

Хүүхдийн уншлагын танхимаас зохион явуулдаг *Бүтээлч уншлага* хөтөлбөр нийт 23 удаа явагдаж 986 сурагч, хүүхдийг хамруулсан байна. Тухайлбал:

- ХУД-ийн 3-р хороо Нийслэлийн 72-р цэцэрлэгийн А.Амартуяа, Д.Отгонжаргал, Д.Наранцэцэг багштай бага "А", "Б", "В" бүлэгт "Ноён наймалж зураг дарсан нь, "Хамтдаа олцгооё ганц эвэрт", "Бадди юу хийж яваа бол" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- ХУД-ийн 3-р хороо Нийслэлийн 72-р цэцэрлэгийн Б.Ариунболор, Б.Рэгзэнханд, Хажидсүрэн багштай дунд "А", "Б", "В" бүлэгт "Би Чи Бид", "Миний Чиний Бидний гэр" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- ХУД-ийн 3-р хороо Нийслэлийн 72-р цэцэрлэгийн Б.Рэгзэнханд, Энхтуул, Б.Янжинтөгс багштай бэлтгэл "А", "Б", "В" бүлгийн хүүхдүүд "Бадди юу хийж яваа бол", "Юуны чимээ вэ?", "Хамтдаа олцгооё! Ганц эвэрт", үлгэрээр
- СХД-ийн 30-р хороо Нийслэлийн 303-р цэцэрлэгийн Р.Хуралай, Г.Наранцэцэг, А.Ариунзаяа багштай бэлтгэл А, Б, В бүлгийн "Хайр хаанаас ирдэг вэ?", "Бумбардай" үлгэрээр
- СХД-ийн 30-р хороо Нийслэлийн 303-р цэцэрлэгийн Ч.Нямдайрий, Г.Ууганбаяр, Э.Алтаншагай багштай ахлах А, Б, В бүлгийн хүүхдүүдэд "Аа-Чүү", "Сургуульд юу болдог вэ" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- СХД-ийн 333-р цэцэрлэгийн Туяацэцэг багштай бага бүлэг Мөнхсарнай багштай дунд бүлгийн хүүхдүүдэд "Бяцхан сахиусан тэнгэр", "Миний муухай ногоон хамар", "Жаргалтай үедээ би" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- СХД-ийн 333-р цэцэрлэгийн Сайханчимэг багштай ахлах бүлэг Д.Бадамханд багштай бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд "Сургуульд юу болдог вэ?", "Сая долларын санаа" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- БГД-ийн Нийслэлийн ерөнхий боловсролын 40-р сургуулийн 2 дугаар ангийн сурагчдад "Би Чи Бид", "Зараа, оготно хоёр", "Тахийн гэрт зочилсон нь" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- СБД-ийн 1-р сургуулийн Д.Цэцэгмаа багштай 3г ангийн сурагчдад "Тусч охин Бөртэ, "Миний гэр", "Үсгийн эрэлд" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- ХУД-ийн 35-р цэцэрлэгийн Мажигсүрэн багштай бэлтгэл "В" бүлгийн хүүхдүүдэд "Ойн амьтад, "Миний гэр" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- ХУД-ийн 35-р цэцэрлэгийн Д.Болортогос багштай бэлтгэл "З" бүлгийн "Бяцхан сахиусан тэнгэр", "Миний гэр" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- ХУД-ийн 35-р цэцэрлэгийн Ц.Шархүү багштай бэлтгэл "З" бүлгийн "Сургуульд юу болдог вэ", "Дуусдаггүй худалч ном" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- СБД-ийн "Оюут" бага сургуулийн С.Баясгагч багштай 1а ангийн сурагчдад "Бяцхан сахиусан тэнгэр", "Миний гэр" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- СХД-ийн 30-р хороо Нийслэлийн 303-р цэцэрлэгийн Ц.Нарантуяа, О.Баярмаа багштай ахлах А, Б, В бүлгийн хүүхдүүдэд "Аа-Чүү", "Сургуульд юу болдог вэ" үлгэрийг уншиж бүтээлч дасгал

- ХУД-ийн 2-р хороо 46-р цэцэрлэгийн Н.Эрдэнэчимэг багштай ахлах "Г" бүлгийн хүүхдүүдэд "Аа-Чүү", "Бяцхан сахиусан тэнгэр" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил,
- ХУД-ийн 2-р хороо 46-р цэцэрлэгийн Н.Мягмарсүрэн багштай ахлах "А" бүлгийн хүүхдүүдэд "Аа-Чүү", "Ганц эвэрт" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил,
- ХУД-ийн 2-р хороо 46-р цэцэрлэгийн Д.Одончимэг багштай ахлах "Б" бүлгийн хүүхдүүдэд "Аа-Чүү", "Чи Би Бид" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил
- ХУД-ийн 2-р хороо 46-р цэцэрлэгийн Д.Одончимэг багштай ахлах "Б" бүлгийн хүүхдүүдэд "Аа-Чүү", "Чи Би Бид" үлгэрийг уншиж бүтээлч дасгал ажил



- БЗД-ийн 321дүгээр цэцэрлэгт "Хайрыг яаж зурах вэ", "Хайр хаанаас ирдэг вэ?" зохиолуудаар уншлага
- СБД-ийн 68-р цэцэрлэгийн хүүхдүүдэд "Хайрыг яаж зурах вэ", "Хайр хаанаас ирдэг вэ?" зохиолуудаар уншлага
- 321-р цэцэрлэгийн дунд бүлгийн хүүхдүүдэд "Бадди юу хийж яваа бол", "Ноён наймаалж зураг дарсан нь" зохиолуудаар уншлага
- 265-р цэцэрлэгийн бэлтгэлийн бүлгийн хүүхдүүдэд "Хайрыг яаж зурах вэ" зохиолыг уншиж хайрын сэдвээр ярилцлага
- Монгол-Оросын хамтарсан сургуулийн 2 ангийн сурагчдад "Бор халзан туулай" зохиолыг уншиж өгч бор халзан туулай гэж юу хэлээд байгааг ярилцаж мэдэж авлаа.

"Үлгэрийн сэтгэл засал"-ын хичээл:

Хүүхдийн сэтгэл зүйч, доктор С.Хулантай хамтран 5–10 насны хүүхдүүдэд зориулсан "Үлгэрийн сэтгэл заслын хичээл" хөтөлбөрийг нийт 6 удаа зохион байгуулж, 240 хүүхдийг хамрууллаа. Хөтөлбөрийн хүрээнд: үлгэрийг зурах хичээл, эцэг, эхтэй хамтарсан үлгэр унших үйл ажиллагаа, үлгэрийн аргаар хүүхдийн сэтгэл зүйг дэмжих, засах арга зүйн хичээл, "Миний бие бол миний найз" сэдвийн хүрээнд өөрийн биеэ танин мэдэх, баяр баясал, гуниг зэрэг сэтгэл хөдлөлд бие хэрхэн хариу үйлдэл үзүүлдгийг ойлгуулах сонирхолтой сургалтуудыг тус тус зохион байгуулсан байна.



"BOOK ART" хөтөлбөр:

Bell art ceramic урлангийн багш М.Баярмаатай хамтран 5-10 нас, 11-15 насныханд зориулан нийт 6 удаа 150 хүүхдийг хамруулан зохион байгууллаа. Үүнд "Өөрийн хүсэл мөрөөдөл", Хамгийн сүүлд уншсан ном, хамгийн дуртай зүйл, мөрөөдлөө", "Цэргийн баярын" тухай аавдаа бэлэглэх", "Мөрөөдөл, хүсэл сонирхол" зэрэг сэдвээр зургийн хичээл орсон байна.





- Номын сангийн фондыг олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах:

Улаанбаатар хотын нийтийн төв болон салбар номын сангийн Фондын ном бусад материалыг сурталчлах зорилгоор түүхэн ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан номын сэдэвчилсэн болон байнгын үзэсгэлэнг нийт 115 удаа гаргасан байна. Үүнээс байнгын 33, сэдэвчилсэн 82 үзэсгэлэнг гаргаж уншигч үйлчлүүлэгчдэд сурталчлсан байна.





- Номын сангийн мэдээлэл, хайлтын системийг сайжруулах

Вэб хуудас

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн вэб <http://www.pl.ub.gov.mn> -ийн агуулгыг шинэчлэн сайжруулахад анхаарч ажилласан. WordPress программын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг 2024 оны 12 дугаар сарын 25-аас 2025 оны 11 дүгээр сарын 28-нийг хүртэлх хугацаанд тайлан гаргахад сард 271 хэрэглэгч зочилж, жилд 174477 хэрэглэгч зочилж, 739702 хуудасны мэдээллийг үзжээ.

Нийт сайтын хэрэглэгчдийн 73.2% нь шинээр орж, 26.8% нь хуучин хэрэглэгчид хэрэглэгчид зочилсон байна.

Вэб хуудас шинэчлэх ажлын хүрээнд байгууллагын вэб сайтыг шинэчилж мэдээ, мэдээлэл оруулж тогтворжуулан ажиллаж байна. Мөн вэб сайтад 57 мэдээ, мэдээлэл оруулсан байна.

Статистик

739702

Visit Today : 271

Visit Yesterday :


This Month : 271

This Year : 174477

Total Visit : 739702

Who's Online : 8

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САН



Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт:

<http://koha.pl.ub.gov.mn> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2024 оны 12 дугаар сарын 05-аас 2025 оны

11 дүгээр сарын 28-нийг хүртэлх хугацаанд 79613 хэрэглэгч зочилж /visits/, 245716 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 87,5% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 12,5% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсан хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.


Country	Visits	% Users
1. Mongolia	35,869	90.50%
2. United States	905	2.14%
3. Russia	581	1.47%
4. South Korea	305	0.82%
5. Japan	281	0.80%
6. China	251	0.61%
7. Ireland	188	0.41%
8. Netherlands	165	0.40%
9. Germany	127	0.31%
10. Sweden	121	0.30%

Интернэт сүлжээ:

Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргүүдэд тус бүрт уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернэтийн үйлчилгээг үнэ төлбөргүй, харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерыг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон.

Үндсэн сүлжээ:


Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 33.77 Mbps, дунджаар 31.99 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 97.26 Mbps, дунджаар 127.37 Kbps хүрсэн байна.



Утасгүй Интернэтийн сүлжээ:

Утасгүй Интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд Интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 5.17 Mbps, дунджаар

10.24 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 71.17 Mbps, дунджаар 14.12 Mbps хүрсэн байна



Тайлангийн хугацаанд суурин интернэтийг 738 хэрэглэгч, утасгүй интернэтийг 1523 хэрэглэгч ашиглаж, нийт 2261 хэрэглэгчид интернэтийн үнэгүй үйлчилгээ үзүүлсэн. Төв болон салбар номын сангуудын интернэт үйлчилгээ хэвийн жигд явагдаж байна.

Америкийн соёл мэдээллийн төв:

Д/д	Хөтөлбөр	Хэдэн удаа явагдсан	Оролцсон хүний тоо
1	Америкийн тухай ярилцъя лекц	7	98
2	Америк багштай хүүхдийн ярианы клуб	43	815
3	Америк багштай номын хэлэлцүүлгийн клуб	29	287
4	Англи хэлний ярианы клуб болон илтэлийн клуб	68	1,515
6	Англи хэл дээрх эсээний хөтөлбөр	19	512
7	Кино үдэш хөтөлбөр	36	353
8	Хамтдаа уншицгаая хөтөлбөр	26	347
9	Номын жим аялалын хөтөлбөрөөр ахлах ангийнханд зориулан "Цаг уурын өөрчлөлт"-ийн талаар лекц орсон	4	395
10	Көүч өдөрлөг	1	85
11	Боловсролын мэдлэг олгох уулзалт (Competitive College club)	30	458
12	"Young Engineer" хөтөлбөр	7	145
13	"MACA"-гийн уулзалт	1	35
15	Англи хэлний зөв дуудлагын хөтөлбөр	13	398
16	Америк монгол судлалын лекц, сургалт	12	259
17	Англи хэлний IELTS бэлтгэлийн анги	30	500
18	The talk at the Globe the AI	15	215
19	The Philosophy Corner 101 program by Sip alumni	8	125
20	НҮБ-ийн загвар хуралдаан	4	75
21	Хосуудын канвас арт хөтөлбөр	1	35
22	"Залуу нас" клубын уулзалт	11	500
24	"Эртэч Монгол" уулзалт	9	235
25	БИ хэн бэ? лекц	1	38
26	Сэтгэлзүйн оношилгоо зөвлөгөө сургалт	5	85
27	Гэр бүлийн эвэнт	1	45
28	Үндэсний бичгийн үзэсгэлэн	1	150
29	Бахархлын өдөрт зориулсан эвэнт	1	35
30	Талархлын баярт зориулсан эвэнт	1	15
31	Сурагчдыг дадлагын хөтөлбөр сонгон шалгаруулалт	2	60
32	Сурагчдын дадлагын нээлтийн үйл ажиллагаа	1	15
	Нийт	387	7830

Америкийн соёл мэдээллийн төв нь тайлант хугацаанд нийт 759 удаагийн соёл, танин мэдэхүйн үйл ажиллагаа зохион байгуулж, 13,220 уншигч, хэрэглэгчийг хамруулан, цахим болон танхимын үйл ажиллагаагаараа нийт 462,252 удаагийн хандалт авсан байна.

- **Мэргэжил арга зүйн сургалт зөвлөгөө:**

Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь 2025 онд ажиллагсдыг чадавхжуулах арга зүйн сургалтыг 10 удаа зохион байгуулж, төв болон салбар номын сангийн нийт 77 ажиллагсдыг хамрууллаа. Үүнд:

1. Хэл бичгийн ухааны доктор, АНУ-ын Вашингтон хот дахь Конгрессын номын сангийн монгол номын мэргэжилтэн М.Саруул-Эрдэнэ урилгаар хүрэлцэн ирж "Дэлхийн Монгол судлалд Монголын номын сангийн үүрэг" сэдвээр
2. ЭМШУТНС-ийн ном зүйч Т.Лувсаннмаа "Номын сангийн үйлчилгээ ба ном зүйн ажил" сэдвээр
3. АМСТ-ийн Түншлэл, олон нийттэй харилцах эрхэлсэн захирал, Олон Улсын Номын Сангийн Холбооны (IFLA) Номын сангийн холбоодын менежментийн зөвлөлийн гишүүн М.Даваасүрэн "IFLA WLIC-Даян дэлхийн номын сангийн чуулган" сэдвээр
4. Үндэсний номын сангийн мэдээлэл арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга, доктор (Ph.D)Т.Хайдав "Хиймэл оюуны боломжийг номын сангийн ажилд ашиглах нь" сэдвээр
5. МУИС-ийн номын сангийн ахлах мэргэжилтэн О.Нарантуяа "Көүч номын сангийн манлайлал, Номын сангийн нийгэмд гүйцэтгэх үүрэг" сэдвээр
6. СБД-ийн ХГБХХХ-ийн Хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Дэлгэрсайхан "Хүүхэд хамгаалал, хуулийн шинэчилсэн найруулга" сэдвээр
7. СБД-ийн ХГБХХХ-ийн Хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарантуул "Байгууллагын эцэг эхийн зөвлөл" сэдвээр
8. ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанаас Эрүүл мэндийн сургалт – "Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх" сэдвээр
9. Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн Ном бүрдүүлэх тусгай үйлчилгээний тасгийн мэдээллийн ажилтан М.Цэнгэл СХД дэх 4-р салбар номын сангийн номын санчдын хүсэлтээр "AI хиймэл оюуныг хэрхэн ашиглаж зураг, дүрс бичлэг контент бүтээх тухай" сэдвээр
10. Төрийн албаны зөвлөлийн "Ёс зүйн хорооны соён гэгээрүүлэх хэлтэс"-ийн дарга Ц.Заяхүү "Төрийн албан хаагчийн ёс зүй, хууль тогтоомж, анхаарах асуудал" сэдвээр
11. Ганабелл институтын көүч, багш С.Одондарьэх "Эрч хүчээ удирдах нь" сэдвээр



Мөн төв болон салбар номын сангуудын үйлчилгээний номын санч нарт ажлын байран дээрх арга зүйн зөвлөн туслах сургалтыг хоёр удаа дараах сэдвээр хийсэн. Үүнд

- “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага” MNS 5742:2019” стандартын тухай
- Номын санд мөрдөгдөж буй зарим стандартуудын тухай ойлголт
- Каталогийн мэдээлэлд засвар хийх
- Номын сангийн мэдээллийн боловсрол
- Номын гэмтлийг сэлбэн засах сургалт



Номын сангийн мэргэжлээр их, дээд сургуульд суралцаж буй дадлага хийхээр ирсэн оюутнууд болон алслагдсан дүүргийн соёлын ордны номын санчдад нийт 20 удаагийн арга зүйн зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэж ажилласан байна. Үүнд Соёлын сургуулийн Номын сан судлал эчнээ ангийн 5 оюутны “Үйлдвэрлэлийн дадлага-”ийг батлагдсан удирдамжийн дагуу нь арга зүйн зөвлөгөөг, Сити их сургуулийн номын сангийн мэргэжлийн 45 хоногийн курсийн 2 оюутанд Номын нэг бүрчилсэн бүртгэл хөтлөх, ном ангилах ерөнхий арга, техник ажиллагаа хэрхэн хийх, цахим каталогт каталогжуулах талаарх арга зүйн зөвлөгөөг, Багахангай дүүргийн Номын санчдад “Ажлын байран дээрх анхан шатны каталогжуулалт”-ын сургалт, ЕБС-ийн 24, 57, 39, 61, 35-р сургуулиудын номын санч, багш, сурагчдад урагдаж гэмтсэн номыг сэлбэн засах сургалтыг тус тус өгч мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.



ТАЙЛАНТАЙ ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

Д.ИНДРА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

Н.ШИНЭГЭРЭЛ